



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/55

Улаанбаатар хот

Хөрөнгө хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” 2019 оны А/55 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Эко эрин тохижилт” ХХК-тай байгуулсан “Мод сөөг хэлбэржүүлэх зориулалттай 7 төрлийн гар багаж /5 ком/ нийлүүлэх ажил” НБ/2019-02 дугаартай, “Зана констракшн” ХХК-тай байгуулсан “Мод сөөг хэлбэржүүлэх зориулалтын бага оврын авто өргөгчтэй машин /автовишка 3ш/-ыг нийлүүлэх ажил” НБ/2019-01 дугаартай гэрээний дагуу нийлүүлэгдэж буй хөрөнгийг нийслэлийн өмчид хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. “Мод сөөг хэлбэржүүлэх зориулалттай 7 төрлийн гар багаж /5ком/”, “Бага оврын авто өргөгчтэй автомашин /автовишка 3ш/-ыг тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтын дагуу актаар хүлээн авах ажлыг зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэг /М.Энхболд/-т, хүлээн авч буй хөрөнгийн бичиг баримтын бүрдлийг ханган холбогдох журмын дагуу данс бүртгэлдээ бүртгэн авч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ /Б.Бямбадорж/-т, Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ /Т.Цэрэнноров/-т нарт тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Ариунбаатар/-д үүрэг болгосугай.


ДАРГА



ОДНАСАН

115050000197

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2019 оны 03 дугаар сарын
20... өдрийн 159 дугаар тушаалын хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:	М.Энхболд	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн төлөөлөл, менежмент, хувьчлалын хэлтсийн дарга
Гишүүд:	Д.Сүхбат	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
	Д.Лувсанчимэг	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит, дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
	С.Батбаатар	Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын орлогч дарга
	Д.Батцэцэг	Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын Ногоон байгууламжийн албаны дарга
	П.Мөнхдэлгэр	Геодези, усны байгууламжийн газар ОНӨААТҮГ-ын Авто баазын дарга
Нарийн бичгийн дарга:	Б.Батаа	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн төлөөлөл, менежмент, хувьчлалын хэлтсийн мэргэжилтэн